

# **СЭЛЭНГЭ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2013 ОНЫ 10 ДУГААР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ**

## **Нэг.Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд:**

### **1.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны талаар:**

2013 оны 10 сарын 18-ны өдөр аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 5-р хуралдаан хуралдаж 7 асуудал хэлэлцэн 7 тогтоол баталлаа. Үүнд:

- Сүүлийн жилүүдэд тус аймгийн нутагт малын тоо толгой өссөн, тариалангийн эргэлтийн талбай нэмэгдснээс малчид, мал бүхий иргэд, тариаланч, ногоочдын дунд ихээр гарах болсон зөрчилдөөнийг оновчтой зохицуулах шаардлагын үүднээс “Малчид тариаланчдын үйл ажиллагааны зохицлыг хангах журам”-ын төслийг хэлэлцэн баталлаа.

- Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2009 оны 2 дугаар тогтоолоор батлагдсан “Аймгийн хөгжлийг дэмжих сан”-гийн журам, 2010 оны 95 дугаар тогтоолоор батлагдсан “Аймгийн жижиг, дунд үйлдвэрийг дэмжих сан”-гийн үйл ажиллагааны журмыг 2013 оноос дагаж мөрдөж байгаа Төсвийн тухай хуульд нийцүүлэн, тус журмын зохицуулалтыг илүү нарийвчлан тодорхой болгож, “Сэлэнгэ аймгийн хөгжлийн сангийн журам”-ын төслийг хэлэлцэн баталлаа.

- Зарим сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргаас ирүүлсэн хүсэлт, аймгийн Засаг даргаас оруулсан саналыг хэлэлцэн Орхон-Сайхан сумдын хилийн цэсэд өөрчлөлт оруулах, мөн Сүхбаатар-Алтанбулаг-Шаамар сумдын хилийн цэсэд өөрчлөлт оруулах саналыг Монгол Улсын Засгийн газарт уламжлах тухай тогтоолыг тус тус баталлаа.

- Сүхбаатар хотыг 2030 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хэлэлцэн баталлаа.

- Аймгийн 2012 оны төсвийн гүйцэтгэлийг хэлэлцэн аймгийн 2012 оны төсвийн орлогыг 18070 084,3 мянган төгрөгөөр, төсвийн зарлагыг 15230 264,4 мянган төгрөгөөр баталлаа.

- Аймгийн 2013 оны төсөвт тодотгол хийж 2013 оны төсвийн орлогыг 62 539869,7 мянган төгрөгөөр, зарлагыг 62 539869,7 мянган төгрөгөөр, аймгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, тоног төхөөрөмж, их засварын зардлын дээд хэмжээг 1 964 750,0 мянган төгрөгөөр, аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас сумын орон нутгийн хөгжлийн санд олгох шилжүүлгийн хэмжээг 5085600,1 мянган төгрөгөөр, тусгай зориулалтын шилжүүлгийн төсвийг 35247643,5 мянган төгрөгөөр, аймгийн төсвөөс сумдад олгох санхүүгийн дэмжлэгийг 10 205 078,4 мянган төгрөгөөр тус тус баталлаа.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид 2 удаа хуралдан 9 асуудал хэлэлцэж 15 тогтоол баталлаа.

Хуралдаанаар малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хууль болон аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас мал аж ахуйн талаар гаргасан тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэх талаар зохиож байгаа ажлын талаар Орхонтуул сумын Засаг даргын сонсголыг хэлэлцлээ.

- Алтанбулаг сумын “Дамбо” цэцэрлэгийн барилгыг орон нутгийн өмчид бүртгэн авахыг аймгийн Орон нутгийн өмчийн албанд даалгалаа.

- Сум орон нутгаас ирүүлсэн хүсэлтийг хэлэлцээд сум байгуулагдсаны 90 жилийн ойгоо 2014 оны 7 дугаар сард тэмдэглэхийг Зүүнбүрэн, Шаамар сумдын иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг дарга нарт зөвшөөрлөө.

- Сүхбаатар суманд үйл ажиллагаа явуулж буй “Христийн Амлалтын Ялалт” сүмийн үйл ажиллагааг 2 жилийн хугацаатайгаар сунгалаа.
- Эрхэлсэн ажилдаа амжилт гаргасан зарим хүмүүсийг төрийн дээд шагналаар шагнуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид уламжиллаа. Үүнд: Гавъяат цолоор 3, “Сүхбаатарын одон”-оор 1, Хөдөлмөрийн Гавъяаны улаан тугийн одон”-оор 6, “Алтангадас одон”-оор 17, “Хөдөлмөрийн хүндэт медаль”-аар 25 хүнийг шагнуулахаар тус тус уламжиллаа. Мөн Сэлэнгэ аймгийн “Хүндэт тэмдэг”-ээр 3 хүнийг шагнахаар шийдвэрлэлээ.

## **2. Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаар:**

Монгол Улсын зэвсэгт хүчний жанжин штабын даргын 2013 оны А/51 тоот тушаалын дагуу тус аймагт 2013 оны 2 дугаар ээлжийн цэрэг татлагыг Мандал, Сайхан, Сүхбаатар суманд бүсчилэн 2013 оны 10 дугаар сарын 15-ны өдрөөс 10 дугаар сарын 21-ний өдрүүдэд зохион байгууллаа. Цэрэг татлагын эмч нарын комиссын үзлэгээр аймгийн хэмжээнд нийт цэргийн насны 18-25 насны 1000 гаруй залуучууд хамрагдлаа.

Аймгийн Засаг даргын Тамгын газраас жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Нээлттэй хаалганы өдөр” арга хэмжээг 2013 оны 9 дүгээр сарын 16-ны өдрөөс 10 дугаар сарын 20-ны өдрийг хүртэл нийт сум, тосгодод зохион байгуулж давхардсан тоогоор нийт 24016 иргэнд үйлчиллээ. Тус арга хэмжээгээр төрийн үйлчилгээг түргэн шуурхай, газар дээр нь иргэдэд нэг цэгээс хүргэж, аймгийн Нэгдсэн эмнэлгийн нарийн мэргэжлийн эмч нар алслагдсан сум, тосгодын иргэдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлдэгээрээ онцлогтой юм.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсээс 2013 оны 10 дугаар сарын 25-ны өдөр аймгийн нийт сумдын төрийн сангийн төлөөлөгч нарт “Төсвийн шинэчлэлт” сэдэвт сургалтыг зохион байгуулж, Төсвийн орлогын төлөвлөлт, цаашид анхаарах асуудал”, “Орлогын гүйцэтгэл”, “Төсвийн зарлага”, “Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлт, тодотгол, хэрэгжилтэнд анхаарах зарим асуудал”, “Орон нутгийн хөгжлийн сангийн программ хангамжийн тухай”, “Нэгдсэн төсвийн 2013 он, 2014 оны төлөв байдал, анхаарах асуудал”, “Худалдан авах ажиллагааны хуулийн хэрэгжилт, 2013 оны байдлаарх гүйцэтгэл, “Орон нутгийн өмчийн бүртгэл, тайлагналт”, “Төсвийн гүйцэтгэлийн мэдээний чанарыг сайжруулах талаар”, “Төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналтыг сайжруулах, хариуцлагыг дээшлүүлэх”, “Төлбөр тооцооны үйл ажиллагаанд тавих хяналт, төрийн сангийн журмуудын хэрэгжилт, тайлан гаргахад анхаарах асуудал”-уудын талаар мэдээлэл хийн нийт 47 мэргэжилтэн хамрагдлаа.

Аймгийн Засаг даргын Тамгын газар, Боловсролын газар, Багшийн мэргэжил дээшлүүлэх институт хамтран “Зөв Монгол хүн” хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх, сургалтын арга зүй, технологи” сэдэвт сургалтыг аймгийн нийт 35 ерөнхий боловсролын сургууль, 37 цэцэрлэгийн 1362 дарга, эрхлэгч, багш нарыг хамруулан зохион байгууллаа.

Аймгийн Засаг даргын Тамгын газраас сумын Засаг даргын Тамгын газар, орон нутагт төрийн үйлчилгээг үзүүлдэг төр төсвийн байгууллагуудын хэвийн үйл ажиллагааг хангуулж, хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийн, төрийн албан хаагчдын чадавхийг сайжруулж, орон нутгийн төрийн албан хаагчдын мэдлэг чадварыг нэмэгдүүлэх зорилгоор Орхон суманд “Шалган туслах” ажлын хэсгийг 2013 оны 10 дугаар сарын 24, 25-ны өдрүүдэд ажиллууллаа. Тус ажлын хэсгээс боловсруулсан ажил сайжруулах тухай зөвлөмжийг Орхон сумын Засаг даргад хүргүүлж, хэрэгжилтэнд хяналт тавин ажиллаж байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газраас аймгийн “Жижиг дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөр” боловсруулж байгаатай холбогдуулан аймгийн Худалдаа аж үйлдвэрийн танхим, Стандартчилал хэмжил зүйн хэлтэс, Хөдөлмөрийн хэлтэстэй хамтран Мандал, Сайхан, Цагааннуур сумдад аж ахуйн нэгж, иргэдийн төлөөллийг оролцуулан хөтөлбөрийн төслийг танилцуулан, хэлэлцүүлэг зохион байгуулж, хэлэлцүүлэгээс гарсан саналыг хөтөлбөрт тусгах арга хэмжээг авлаа.

Залуучуудын улсын аварга шалгаруулах волейболын тэмцээнийг аймгийн Засаг даргын Тамгын газар, Соёл, спорт, аялал жуулчлалын газар, Монголын болон аймгийн волейболын холбоо, Витафит групп ХХК хамтран 2013 оны 10 дугаар сарын 19-өөс 23-ны өдрүүдэд тус аймагт зохион байгууллаа. Тэмцээнд эрэгтэй эмэгтэй нийт 11 багийн багийн 125 тамирчин багц медалийн төлөө өрсөлдөж 22 дасгалжуулагч ажиллалаа. Тэмцээнд эрэгтэй ОУХМ Б.Уранчимэг дасгалжуулагчтай Алтайн барс баг, удаах байранд Д.Солонго дасгалжуулагчтай Хасумега старс, Спортын мастер С.Тамираа дасгалжуулагчтай МУБИС-ийн багууд шалгарч, эмэгтэй ОУХМ Д.Хэрлэн дасгалжуулагчтай Монстар, ОУХМ Б.Уранчимэг дасгалжуулагчтай Алтайн барс, Г.Баярсайхан дасгалжуулагчтай Сэлэнгэ ТЭЦ 4 багууд эхний 3 байранд шалгарлаа.

Монгол-Оросын найрамдлын сарын аяны хаалтын үйл ажиллагааг 2013 оны 11 дүгээр сарын 1-ний өдөр тус аймагт зохион байгуулж, Сэлэнгэ аймаг, ОХУ-ын Буриад улсын Хиагтын район хоорондын хамтын ажиллагааны гэрээг шинэчлэн байгууллаа. Тус арга хэмжээний хүрээнд Хиагтын орон нутгийг судлах музейгээс Н.А Чарушины XIX зууны үеийн Монгол, Оросын амьдралыг харуулсан фото зургийн үзэсгэлэнг гаргалаа.

### **Хоёр.Эдийн засаг, санхүүгийн бодлогын хүрээнд:**

#### **1.Төсвийн гүйцэтгэлийн талаар:**

09-р сарын 31-ний байдлаар

/мянган төгрөгөөр/

д/д	Үзүүлэлтүүд	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
1	Орон нутгийн төсвийн орлого	11689913.3	11275172.2	96.5%
2	Үүнээс: Аймгийн төсвийн орлого	9582875.5	8334678.9	87.0%
3	Орон нутгийн төсвийн зарлага	42186942.7	36452136.9	86.4%
	Үүнээс: Аймгийн төсвийн зарлага	11774094.2	8616823.9	73.2%
	Аймгийн ОНХСангийн зарцуулалт	2085228.0	1180753.6	56.6%
	Авто замын хөрөнгө оруулалт	208380.9	49830.0	23.9%
4	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт	1297525.1	610382.9	47.0%
5	Сумдад олгосон санхүүгийн дэмжлэг	8055906.7	8066217.8	100.1%
6	Засаг даргын нөөц	341325.3	367208.5	107.6%

2013 оны төсвийн гүйцэтгэлийн 3-р улирлын мэдээгээр орон нутгийн төсвийн орлого 96.5 хувь, улсаас авах санхүүгийн дэмжлэг 100.0 хувь, орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг 64.7 хувь, салбарын байгууллагуудын тусгай зориулалтын шилжүүлэг 99.9 хувь тус тус биелэгдсэн байна. Төсвийн зарлагын

гүйцэтгэл 86.4 хувийн биелэлттэй, сумдын санхүүгийн дэмжлэг 100.1 хувь, Засаг даргаас олгох нөөц хөрөнгийн гүйцэтгэл 107.6 хувийн гүйцэтгэлтэй байна.

**2.Өргөн хэрэглээний барааны үнэ ханшийн тухай:**

№	Барааны нэр, төрөл	Хэмжих нэгж	Үнэ, ханш /төгрөгөөр/	
			2012 оны 9-р сар	2013 оны 10-р сар
<b>Нэг.Талх, гурил, будаа</b>				
1	Гурил /1-гурил/	1 кг	800	800
2	Талх /орон нутгийн/ том, жижиг	ш	800-1600	800, 1800
3	Нарийн боов	1 кг	1800-2300	1800-2300
4	Элсэн чихэр	1 кг	1600	2000
5	Цагаан будаа	1 кг	2000	2200
<b>Хоёр.Мах, махан бүтээгдэхүүн</b>				
6	Хонины мах	1 кг	7500	6500
7	Үхрийн мах	1 кг	8500	7000
8	Адууны мах	1 кг	600	6300
9	Ямааны мах	1 кг	6500	6000
10	Дотор мах цувдай	1 кг	4000	4500
11	Хиам, чанасан	1 кг	8500	8500
12	Гахайн мах	1кг	7000	7000
<b>Гурав.Сүүн бүтээгдэхүүн</b>				
12	Сүү /задгай/	1л	700	800
13	Сүү /савласан/	1л	1700-1800	1700-1800
14	Тараг /задгай/	1л	800	1000
15	Хорхой ааруул	1 кг	5000	5000
16	Айраг	1л	2500	-
17	Хуурай сүү /орос/	1 кг	4200	4200
18	Өндөг	ш	250-280	330-350
<b>Дөрөв. Бүх төрлийн өөх тос</b>				
19	Ургамлын тос	1 кг	2800-3200	2900-3500
20	Өөхөн тос	1 кг	1200	1200
21	Шар тос	1 кг	8000	8000
22	Масло /задгай/	1 кг	3000	3000
<b>Тав.Хүнсний ногоо</b>				
23	Төмс/Монгол/	1 кг	400	600
24	Лууван	1 кг	500	800
25	Манжин	1 кг	1500	800
26	Байцаа	1 кг	500	600
27	Сонгино	1 кг	1500	1500
28	Өргөст /Монгол/ хэмх	1 кг	-	-
29	Тарвас /Монгол/	1 кг	1500	-
30	Өргөст /даршилсан/ хэмх	ш	3000-4200	3000-4200
31	Алаг /даршилсан/ салат	ш	2100-2500	2100-2500

Зургаа.Тээвэр шатахуун				
32	Бензин А-80	1 л	1540	1540
33	Бензин А-92	1 л	1650	1650
34	Дизель түлш	1 л	1780	1780

### **Гурав.Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд:**

#### **1.Архивын талаар:**

“Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийн явцын тайлан мэдээ, судалгааг гаргаж аймгийн Засаг даргын Тамгын газрын даргаар баталгаажуулж Архивын ерөнхий газарт хүргүүллээ.

Жавхлант, Алтанбулаг сумын 75 ортой хүүхдийн цэцэрлэгийн барилга, Сайхан сумын 40 айлын орон сууц, Орхон сумын халуун усны барилга, Сүхбаатар сумын УТ-6 дугаар хэсэг Төмөр замын дулаан хангамжийн шугам шинэчлэх ажлын баримт бичиг, Сайхан сумын Хөтөл хотын доторхи иженерийн шугамын их засварын ажил, Сүхбаатар сумын Партизаны талбайн шинэчлэлийн ажлын баримт бичгийг хүлээн авч хөмрөгт байрлууллаа.

Эрдэм шинжилгээ, техник боловсруулалтын ажлыг Сайхан сумын Засаг даргын Тамгын газрын хөмрөгийн 60 хадгаламжийн нэгж, Цагаантолгойн сангийн аж ахуйн 17 хадгаламжийн нэгж буюу нийт 8121 хуудас бүхий баримтанд мастер хувь үүсгэн, үдэж хавтаслан нүүрний бичилт хийн хөмрөгт байрлууллаа.

Сүхбаатар сумын Усны аж ахуйн удирдах газар, Сайхан сумын Ардын депутатуудын хурлын гүйцэтгэх захиргаа, Сант сумын Цагаантолгой сангийн аж ахуйн хөмрөгүүдэд иж бүрэн нягтлан шалгалт хийж, дансны дахин боловсруулалт, тоон хэлбэрт шилжүүлэх баримтын судалгаа, устгах бичгийн жагсаалт, сэлбэн засах баримтын судалгаануудыг тус бүр гаргалаа.

Мастер хувиас Алтанбулаг сангийн аж ахуйн 6 хадгаламжийн нэгжийн 1209 хуудсанд ашиглалтын хувь үүсгэх ажлыг хийлээ.

Сант сумын Засаг даргын Тамгын газрын хөмрөгийн 20 хадгаламжийн нэгж, Баруунхараа сангийн аж ахуйн нэгжийн хөмрөгийн 17 хадгаламжийн нэгжид сэлбэн засалтын ажлыг хийлээ.

Иргэд, албан байгууллагын хүсэлтийн дагуу архивын хуулбар 83, архивын магадлагаа 11, тодорхойлолт 16 гаргаж үйлчиллээ.

### **Дөрөв.Нийгмийн хөгжлийн бодлогын хүрээнд:**

#### **1.Боловсролын чиглэлээр:**

“Монгол, Орос улсын найрамдал”-ын сарын аяны хүрээнд Сүхбаатар, Алтанбулаг сумын ерөнхий боловсролын 7 сургуулийг хамруулан “Орос дууг хэн сайн дуулах вэ?”, “Орос шүлгийг хэн сайн унших вэ?”, “Хэн олон орос үг мэдэх вэ?” АХА тэмцээн уралдаан болон “Орос орон миний нүдээр” гар болон фото зургийн уралдааныг зохион байгуулж байна.

Ерөнхий боловсролын сургуулийн 1-3 дугаар ангийн сурагчдыг дүрэмт хувцсаар жигдрүүлэх ажлыг Дархан-Уул аймаг дахь “Шүтээн-Уул” ХХК-тай хамтран зохион байгуулж Сүхбаатар, Мандал чиглэлийн сургуулийн сурагчдад олголоо. Сүхбаатар, Цагааннуур чиглэлийн 10 сургуулийн 881 сурагч /72,3 хувь/ шинэ хувцасаар жигдрээд байна.

Аймгийн Боловсролын газраас дутагдалтай сурах бичгийн судалгааг гаргаж, нэмж ирсэн 115 багц номыг дутагдалтай байгаа Сүхбаатар сумын 4-р сургууль, Баруунбүрэн, Зүүнбүрэн, Мандал, Сайхан, Түшиг, Хүдэр, Цагааннуур, Шаамар,

Жавхлант, Орхонтуул зэрэг сумдын 10 ерөнхий боловсролын сургуулиудад олгох ажлыг зохион байгууллаа.

2011-2012, 2012-2013 оны хичээлийн жилд МУБИС-ийг төгсөн анхны жилдээ ажиллаж буй цэцэрлэгийн 44 багшийн багшлах эрхийг олгуулахаар материалыг хянаж “Багшийн мэргэжил дээшлүүлэх институт”-д хүргүүллээ.

## **2.Эрүүл мэнд, биеийн тамирын чиглэлээр:**

Тус аймагт дархлаажуулалтын 10 хоногийг “Дархлаажуулалт бүхий халдварт өвчнөөс сэргийлье” уриан дор 2013 оны 10 дугаар сарын 10-наас 20-ны өдрүүдэд зохион байгуулж, товлолын вакцинаас хоцорсон 44 хүүхдийг САА, УГУ, 5-т, вируст гепатит А эсрэг вакцинаар дархлаажууллаа.

Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлэг, сум, өрхийн Эрүүл мэндийн төвийн нийт 750 эмч эмнэлгийн мэргэжилтэнг Томуугийн эсрэг вакцинд хамруулах ажлыг зохион байгууллаа.

Дэлхийн гар угаах өдрийг тохиолдуулан “Цэвэр гар-Эрүүл амьдралын үндэс” уриан дор сарын аян зарлаж аймгийн нийт 32 ерөнхий боловсролын сургууль, 28 цэцэрлэгт удирдамжийг хүргүүлэн, 6500 гаруй хүүхдүүдэд “Эрүүл амьдрал таны гарт” сэдэвт сургалт хийн “Гар угаахын ач тус, “Гарын ариун цэвэр” сэдвээр зөвлөгөө өгч, гарын авлага тараалаа.

Хавдар судлалын үндэсний төв, Хаан банк, Монголын Үндэсний Олон Нийтийн Радио телевизтэй хамтран хэрэгжүүлж буй “Хавдрын эсрэг үндэсний аян 2013” Сэлэнгэ аймгийн Мандал суманд 2013 оны 10 дугаар сарын 14-20-ны өдрүүдэд 7 хоногийн хугацаатай зохион байгуулагдаж нийт 1700 хүн үзлэгт хамрагдан, мэс заслын хагалгаа 9 өвчтөнд хийгдэж, хорт хавдрын шинэ тохиолдол 2-ыг илрүүлж хавдрын сэжигтэй 10 хүнийг онош тодруулах шинжилгээнд хамруулахаар боллоо.

Аймгийн Засаг даргын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор аймгийн 16 сум, 6 тосгоны ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн нийт 1625 хүүхдийг шүдний эмчийн үзлэгт хамруулан эрүүл 1219 хүүхэд, өвчтэй 406 хүүхэд оношлогдож, эмчилгээ хийн, шүдээ хэрхэн арчлах талаар зөвлөгөө өглөө.

Аймгийн Эрүүл мэндийн газраас сум, тосгоны Эрүүл мэндийн төвүүдэд 2013 оны 9 дүгээр сарын 26-аас 10 сарын 20-ны өдрүүдэд хүлээн авах, яаралтай тусламж болон хүүхдийн үйлчилгээний чанар, аюулгүй байдалд хяналт шалгалт хийн, зөвлөгөө дэмжлэг үзүүллээ.

Ахмадын өдөрт зориулан Волейбол, шатар, дардас, ширээний теннис зэрэг спортын арга хэмжээг зохион байгуулж 120 гаруй ахмадууд оролцон багийн дүнгээр Сүхбаатар сумын 7-р баг тэргүүлэн шилжин явах цомын эзэнээр тодорлоо.

Аймгийн соёл, спорт, аялал жуулчлалын газар, Дэлхийн зөн олон улсын байгууллагатай хамтран ерөнхий боловсролын сургуулиудын сурагчдын дунд спортын таван төрөлт сайн санааны спортын анхдугаар наадмыг зохион байгуулан 12 сургуулийн 480 гаруй тамирчид оролцон багийн дүнгээр Сүхбаатар сумын 12 жилийн 6 дугаар сургууль 32 оноогоор тэргүүн байранд шалгарч шилжин явах цом иж бүрэн спортын хэрэглэл материалаар шагнагдлаа.

Идэрчүүдийн Улсын аварга шалгаруулах Волейболын тэмцээнийг Мандал суманд 2013 оны 9 дүгээр сарын 22-29-ний өдрүүдэд зохион байгуулж, нийт эрэгтэй 18, эмэгтэй 26 багийн 400 гаруй тамирчид оролцон эрэгтэй багаас Чингэлтэй дүүргийн 21-р сургууль, Сэлэнгэ, Дархан-Уул аймаг, эмэгтэй Дундговь, Хэнтий, Дорнод аймгийн баг эхний байранд шалгарлаа.

Соёлын ажилтны өдөр, аялал жуулчлалын өдөр, Монгол Улсад кино байгууллага үүсч хөгжсөний 80 жилийн ойд зориулан спортын арга хэмжээг аймгийн

нийт сум, тосгодын соёлын төвүүдийн дунд зохион байгуулж нийт 180 гаруй тамирчид оролцож багийн дүнгээр Орхон сумын соёлын төв тэргүүлээ.

### **3.Нийгмийн даатгалын талаар:**

Нийгмийн даатгалын сангуудад 15572.7 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл оруулах төлөвлөгөөтэйгээс 15913.5 сая төгрөг хурааж, төлөвлөгөөний биелэлт 102.1 хувьтай байна. Аймгийн хэмжээнд 19 нэгжээс 16 нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөг 3,1-35,7 хувиар давуулан биелүүллээ.

Тайлант сард тэтгэврийн даатгалын сангаас 14714 тэтгэвэр авагчдад 23864.9 сая төгрөгийн тэтгэвэр олгон, тэтгэмжийн даатгалын сангаас 4505 даатгуулагчдын хөдөлмөрийн чадвар түр алдалт, жирэмсэн амаржсан, оршуулга 1196.0 сая төгрөгийг зарцууллаа.

Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангаас 323 тэтгэвэр авагчдын 845.3 сая төгрөг, ажилгүйдэлийн даатгалын сангаас 377 хүнд 300.5 сая төгрөгийн тэтгэмжийг олгон, эрүүл мэндийн даатгалын сангаас эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн 40016 хүний үй ÷ëëãýí èé çàðààëä, үй èéí ñàí ääàð çéë÷ë¿ëñýí 8670 äààðõóóëäã-äü í çàðààëä нийт 2984.1 сая төгрөгийг шилжүүлээд байна.

Аймгийн Нийгмийн даатгалын хэлтсээс шүүхийн шийдвэртэй 8 аж ахуйн нэгж, байгууллагын 117776,9 мянган төгрөг, 2013 оны 3 дугаар улирлын байдлаар 16 сумын сургууль, цэцэрлэг, Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв гэсэн 45 төсвийн байгууллагын 232156,0 мянган төгрөгийн авлагыг жагсаан аймгийн Боловсролын газарт хүргүүлэн, өрийг барагдуулахаар хамтран ажиллаж байна.

Аймгийн Нийгмийн даатгалын хэлтсээс 2013 оны эхний хагас жилд төсвийн 17 сум 2 тосгоны 119 байгууллагын нийгмийн даатгалын шимтгэлийн 578809,8 мянган төгрөгийн авлагыг тус бүрээр нь жагсаан сумдын Засаг дарга нар, аймгийн Засаг даргын Тамгын газрын санхүү төрийн сангийн хэлтэст хүргүүллээ.

### **4. Нийгмийн халамжийн үйлчилгээний талаар:**

Ахмад настанд үзүүлэх хөнгөлөлт тусламжинд 743 иргэнд 184179.3 мянган төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлэх хөнгөлөлт тусламжинд 697 иргэнд 65765.6 мянган төгрөг, жирэмсэн, хөхүүл нярай 2533 эхэд 819894.3 мянган төгрөг, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд 867 иргэнд 45707.4 мянган төгрөг, алдарт эхийн 1, 2 дугаар зэргийн одонтой 8522 эхэд 1160680.0 мянган төгрөг, хүнсний эрхийн бичиг олгох үйлчилгээнд 18825.0 мянган төгрөг, алдар цолтой ахмадуудад үзүүлэх хөнгөлөлт тусламжийн үйлчилгээнд 58 иргэнд 77365.0 мянган төгрөгийг тус тус олголоо.

### **5. Хөдөлмөр эрхлэлтийн талаар:**

2013 оны 9-р сарын байдлаар бүртгэлтэй ажилгүй иргэд 967 хүн байсан бол 155 иргэн шинээр бүртгүүлж ажил олгогчоос ирүүлсэн 141 ажлын байранд 128 хүнийг ажилд зуучилж ажилгүйчүүдийн тоо 994 боллоо.

Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 60, 2013 оны 192 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор, аймгийн Хөдөлмөрийн хэлтсийн даргын баталсан удирдамжийн дагуу аймгийн Мэргэжлийн хяналтын газар, Цагдаагийн газар, Хөдөлмөрийн хэлтсээс хамтран “Хөтөлийн Цемент шохой” хувьцаат компанид хяналт шалгалт хийлээ.

Алтанбулаг, Мандал сумдын Ерөнхий боловсролын 4 сургуулийн 10 бүлгийн ахлах ангийн 236 сурагчдад “Мэргэжил бүхэн сайхан” сэдэвт сургалтыг зохион байгууллаа.

Аймгийн Хөдөлмөрийн хэлтсээс Баянгол сум, Түнхэл тосгонд хөдөлмөрийн өдөрлөг яармаг зохион байгууллаа.





Зүүнбүрэн сумын иргэн, аж ахуй нэгжийн төлөөлөл, төрийн албан хаагч нарт зориулсан тэдгээрийн газрын харилцааны талаарх мэдлэг мэдээллийг нэмэгдүүлэх зорилгоор “Сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулахад төрийн үүрэг, иргэдийн оролцоо” сэдэвт сургалтыг зохион байгууллаа.

Сүхбаатар сумын 19 иргэн одоо эзэмшиж буй хашааны газраа өмчлөхийг хүссэн хүсэлт ирүүлсэнээс 18 иргэнд 1.8 га газрыг аймгийн Засаг даргын шийдвэрээр газар өмчлүүлэх асуудлыг шийдвэрлүүллээ.

“Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль”-ийн дагуу хамтран өмчлөх эрх шилжүүлэхээр хүсэлт гаргасан 13 иргэний газар өмчлөх эрхийг нээж 6 иргэнд газар өмчлөх эрхийг хэвээр үлдээлээ.

Алтанбулаг, Баянгол, Мандал, Орхон, Сайхан, Шаамар сумдын нийт 43 иргэний өмчилсөн газрыг кадастрын мэдээллийн санд бүртгэж, баталгаажуулан Газрын харилцаа барилга хот байгуулалтын газраас Улсын бүртгэлийн хэлтэст шилжүүллээ.

Эзэмшиж ашиглаж буй газраа эдийн засгийн эргэлтэнд оруулж арилжааны банкинд газар эзэмших эрхийн гэрчилгээгээ барьцаалсан тухай улсын бүртгэлд 1 аж ахуйн нэгж 20 иргэний нийт 21 нэгж талбарыг бүртгэж аймгийн төрийн санд тэмдэгтийн хураамжийн 210.0 мянган төгрөгийг төвлөрүүллээ.

## **2.Байгаль орчны талаар:**

Аймгийн Байгаль орчны газраас нийт сумдад их цэвэрлэгээний ажил зохион байгуулж байна.

Алтанбулаг сумын нутаг дэвсгэр Сайхны хөтөл, Номтын аялал жуулчлалын баазын хог хаягдлыг бүрэн цэвэрлүүлж хариуцах эзэнтэй болгох талаар Байгаль орчны газраас сумын Засаг даргын Тамгын газартай хамтран ажиллаж байна.

Байгаль хамгаалах сарын аяны хүрээнд ерөнхий боловсролын 2-р сургуулийн 9-р ангийн 60 сурагчдад байгаль орчны эрх зүйн шинэчлэлийн талаар хууль эрх зүйн анхан шатны мэдлэг олгох сургалтыг явуулж, аха тэмцээн зохион байгууллаа.

## **3.Тээвэр авто замын талаар:**

Авто тээврийн үндэсний төвийн Сэлэнгэ аймаг дахь салбар, аймгийн Тээвэр авто замын газар хамтран нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн тээврийн хэрэгслийн давтан үзлэгийг аймгийн хэмжээнд бүсчилэн Мандал, Баянгол, Сайхан, Сүхбаатар сумдад зохион байгуулж байна.

Аймгийн Тээвэр авто замын газраас улсын чанартай авто замаар хүнд даацын тээврийн хэрэгслээр тээвэр эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн тээвэрлэлтийн үйл ажиллагаа, тээврийн хэрэгсэл, ачааны байдалд явуулын пүүг ашиглан “Авто замын тухай”, “Автотээврийн тухай”, “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай” хуулиудын хэрэгжилтэнд хяналт шалгалтыг хийж гүйцэтгэлээ.

Нийтийн тээврийн үйлчилгээ эрхэлж буй аж ахуйн нэгжүүдийн тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдал, осол авааргүй зорчигч тээвэрлэлтийг явуулж байгаа байдалд өдөр тутмын хяналт шалгалтыг хийж, Баянгол, Сайхан, Сант сумдад нийтийн тээвэр үйлчилгээ эрхэлж буй аж ахуйн нэгжүүдийн тээврийн хэрэгсэл болон зорчигч болон ачаа тээвэр, иргэдийн тээврийн хэрэгсэлд авто тээврийн хяналт шалгалтыг хийн ажиллалаа.

## **Долоо.Сум орон нутгийн талаар:**

### **1.Баруунбүрэн сум:**

Сумын хэмжээнд адуунаас бусад бүх мал сүргийн төлийг нүдэнд дусаах аргаар вакцинжуулах ажлыг зохион байгуулж, 20 өрхийн өвөлжөө хашааг ариутгаад байна.

Модны хулгайн Хууль бус үйлдэлтэй тэмцэх зорилгоор тус сумын Байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч, цагдаа нар хамтран эргүүл шалгалтын ажлыг тайлант сард 5 удаагийн ажлыг зохион байгууллаа.

40-өөс дээш болон ахмад настай иргэд, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хамрагдсан мэргэжлийн өндөр дадлага туршлагатай ахмадууд тус сумын залуучуудад төсөл бичих, Трактор комбайны жолооч, засварын сургалтыг зохион байгууллаа.

Албан бус боловсрол төвийн дэргэд 15 хүний бүрэлдэхүүнтэй бүлэг байгуулж, харилцан туршлага солилцох чиглэлээр ногоо даршлах, эсгий шаахай хийх, оёдол эсгүүр хийх зэрэг сургалтуудыг зохион байгуулж байна.

АДРА олон улсын байгууллагаас санхүүжүүлж буй сүү шимийн сургалтыг 15 өрхөд зохион байгуулж, барилгын өрлөг, засал чимэглэлийн мэргэжил олгох сургалтанд 15 иргэнийг хамрууллаа.

## **2.Баянгол сум:**

Тус сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчид тайлант сард хуралдаж “Ногоон сум” сумын дэд хөтөлбөр, Статистик мэдээ мэдээллийг сайжруулах, хөгжүүлэх төлөвлөгөө, Малын жишиг үнэлгээ, Сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хяналтын хорооны бүрэлдэхүүнийг тус тус баталлаа.

Тус сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Нийгмийн бодлогын хорооноос Эрүүл мэндийн төвийн ажил үйлчилгээтэй танилцах, хяналт шалгалтын ажлыг хийж, эрүүл мэндийн төвийн эмч, мэргэжилтнүүдтэй уулзалт, зохион байгуулж, цаашид анхаарах зарим асуудлаар ярилцлаа.

Төв аймгийн Батсүмбэр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид, тус сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагаатай танилцах, туршлага солилцох зорилгоор, 2013 оны 10 дугаар сарын 18–19-ны өдөр тус суманд ажиллаж, төр төсвийн байгууллагуудын үйл ажиллагаатай танилцлаа.

Тайлант сард Баянгол сумын Засаг даргын Тамгын газраас “Ногоон сум”, “Малчид тариаланчдын үйл ажиллагааны зохицлыг хангах журам”-ын талаар хэлэлцүүлэг зохион байгуулж нийт 60 орчим малчин, тариаланч иргэд оролцлоо.

2013 оны 10 дугаар сарын 17-ны өдөр тус сумын Засаг даргын баталсан удирдамжийн хүрээнд сумын Засаг даргын Тамгын газар, Эрүүл мэндийн төв, Цагдаагийн хэсэг хамтран, архи, согтууруулах ундаа худалдан борлуулдаг, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн худалдан борлуулдаг, түүгээр үйлчилдэг аж ахуй нэгж байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийн, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах арга хэмжээ авч ажиллаж байна.

## **3.Ерөө сум:**

Тус сумын Засаг даргын Тамгын газраас тус суманд үйл ажиллагаа явуулж буй төр төсвийн байгууллага, Бугант тосгоны захирагчийн албаны иргэдэд үзүүлж буй төрийн үйлчилгээний чанар, хүртээмжинд хяналт шалгалт хийх ажлыг зохион байгууллаа.

Ерөө сумын 90 жилийн ойг угтан 2013 оны 9 дүгээр сар 15-наас 2014 оны 6-р сарын 15 хүртэл “Цэвэр орчин ногоон төгөл” болзолт аян зарлалаа.

Сумын Засаг даргын Тамгын газрын “Иргэний танхим”-д төр төсвийн байгууллагуудын цаг үеийн мэдээллийн самбар байрлуулж мэдээллийг баяжуулан ажиллаж, интернетийн үйлчилгээг үнэ төлбөргүйгээр иргэдэд хүргэж байна.

2013 оны 10 дугаар сарын 20-ны өдөр аймгийн Онцгой байдлын газар, сумын Засаг даргын Тамгын газар, Дэлхийн зөн олон улсын байгууллага хамтран иргэдийг гамшгаас хамгаалах ажиллагаанд сургаж дадлага эзэмшүүлэх, эрсдэлийг бууруулах,







Ерөнхий боловсролын сургуулиудын сурагчдын авъяасыг дэмжин, хөгжүүлэх зорилгоор зохиогддог Дэлхийн зөн олон улсын байгууллагын “Зөнгийн одод” урлагийн наадам болж, улсын тэргүүний 1-р сургууль түрүүлж, 3,0 сая төг, улсын тэргүүний 4-р сургууль дэд байранд шалгарч 2,0 сая төгрөгөөр шагнагдлаа.

Гамшгаас хамгаалах дэлхий нийтийн өдрөөр аймгийн Онцгой байдлын газар тус сумын Засаг даргын Тамгын газар хамтран нийт 33 Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд “Гамшгаас хамгаалахад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоо” сэдэвт сургалтыг зохион байгууллаа.

Ахмадын баярын өдрөөр тус сумын Засаг даргын Тамгын газраас “Ахмадын өдөрлөг” зохион байгуулж, ахмад настны хөдөлмөр эрхэлэлтийг дэмжин үзэсгэлэн худалдаа гаргалаа. Үүнд: 19 төрлийн сүү, цагаан идээ, 31 оёмол хатгамал, 17 төрлийн жимс жимсгэнэ, 9 төрлийн мах махан бүтээгдэхүүн, нийт 317 ширхэг бүтээгдхүүнээр иргэдэд үйлчилгээ үзүүллээ.

#### **12.Алтанбулаг сум:**

2013 оны 10 дугаар сарын 12-ны өдөр сумын Засаг даргын Тамгын газраас бүх нийтээр мод тарих өдрийг зохион байгуулж төсвийн 6 байгууллага, төрийн бус байгууллага, ойн санг гэрээгээр эзэмшигч нөхөрлөлүүд нийлсэн 11 байгууллагын 340 гаруй иргэдийг хамрууллаа.

Алтанбулаг, Сүбхаатар сумдын 168 иргэн, аж ахуйн нэгжид нийт 765 м<sup>3</sup> галын түлээ, Нутгийн хишиг нөхөрлөлийн холбоонд 25 м<sup>3</sup>, Ногоон нарс ХХК-д 45 м<sup>3</sup> хэрэглээний модыг олголоо.

Сумын Эрүүл мэндийн төв нь тайлант сард нийт 305 хүнд үзлэг хийснээс урьдчилан сэргийлэх үзлэгт 80 хүн, идэвхтэй үзлэг 110 хүнд, гэрийн эргэлтээр 42 хүнийг хамруулсан байна.

Ор хоног ашигласан 103, эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн 14, нас баралт 1 байж, дуудлаганд 48 удаа гарснаас алсын дуудлагаар 8 удаа үйлчиллээ.

Тус сумын ерөнхий боловсролын сургуулиас төсвийн байгууллагын ажилчдын дунд “Бид хамтдаа” нөхөрсөг спортын тэмцээнийг зохион байгууллаа.

#### **13.Хүдэр сум:**

Ахмадын өдрийг угтаж ахмадын хорооны саначлагыг дэмжиж тус сумын Засаг даргын Тамгын газар “Юу чаддагаараа үлгэрлэе” үзэсгэлэн худалдааг зохион байгуулж, сумын 20 гаруй ахмад настан өөрсдийн хийсэн бүтээлээр оролцлоо.

Тус сумын нутаг дэвсгэрт ойгоос мод бэлтгэсэн аж ахуйн нэгж иргэдийн бэлтгэсэн газарт сумын Засаг даргын Тамгын газар, Мэргэжлийн хяналтын газар хамтран хяналт, шалгалт хийж баримтжуулан зөрчил гаргасан этгээдийг хууль хяналтын байгууллагад шилжүүлэн шалгуулж байна. Тайлант сард түлээний гоожингийн хураамжинд 2.5 сая төгрөгийг орон нутгийн дансанд төвлөрүүллээ.

Тус сумын Засаг даргын Тамгын газар, Бугантын мод үржүүлгийн газартай хамтран Хүдэр сумын Шанд хэмээх газар үржүүлгийн сургалт зохион байгуулж 20 гаруй иргэдийг хамрууллаа.

Бичил уурхай эрхлэгчдэд тус сумын Засаг даргын Тамгын газраас Нийгмийн даатгал, Эрүүл мэндийн даатгал, хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр сургалт зохион байгуулж нийт 40 гаруй иргэдийг хамрууллаа.

Ерөө бүсийн цэцэрлэгүүдийн дунд жил бүр уламжлал болон зохион байгуулагддаг Урлаг спортын тэмцээнийг Хүдэр суманд зохион байгуулж нийт 5 багийн 90 гаруй тамирчид спортын 7, урлагийн 5 төрлөөр өрсөлдөж, тус сумын цэцэрлэг шилжин явах цомыг 2 дахь удаагаа хүртлээ.

#### **14.Цагаануур сум:**

Тус суманд үйл ажиллагаа явуулж буй төр, төсвийн байгууллага, аж ахуйн нэгжүүдийн удирдах ажилтнуудын уулзалтыг 2013 оны 10 дугаар сарын 2, 7-ны өдрүүдэд тус тус зохион байгуулж, тус үйлдэгдэж буй хулгайн гэмт хэрэг болон, тус сумын 90 жилийн ойг угтаж хийгдэх бүтээн байгуулалт, цаг үеийн ажлуудаар санал бодлоо солилцлоо.

Тус сумын Засаг даргын Тамгын газраас төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг 6 удаа хийж, эрхийн бичиггүйгээр ойгоос мод бэлтгэсэн, зөрчил гаргасан 1 иргэнийг илрүүлж 951.0 мянган төгрөгийн торгууль ногдууллаа.

Аймгийн Хөдөлмөрийн хэлтэс, сумын Засаг даргын Тамгын газар хамтран “Лхамхайн булаг”, “Бэлийн булаг”-ийг хашиж хамгаалан 35 иргэнийг түр ажлын байраар хангалаа.

Тус сумын Засаг даргын Тамгын газраас нийтийн эдэлбэр газрын цэвэрлэгээг 2 удаа зохион байгуулж тус суманд үйл ажиллагаа явуулж буй төр, төсвийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэд оролцон нийт 10 тн хогийг хогийн нэгдсэн цэгт хүргүүллээ.

Цагааннуур, Зүүнбүрэн, Түшиг сумдын “Өрхийн болон жижиг, дунд үйлдвэрлэл-2013” үзэсгэлэн худалдааг зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангаж байна.

#### **15.Шаамар сум:**

Сумын Засаг даргын Тамгын газар, аймгийн Цагдаагийн газар, Дэлхийн зөн олон улсын байгууллага хамтран гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг сурталчлах өдөрлөгийг 2013 оны 10 дугаар сарын 4-ний өдөр зохион байгууллаа.

Сумын Засаг даргын Тамгын газраас Дулаанхаан тосгоны захирагчийн албаны үйл ажиллагаанд хяналт шалгалт хийлээ.

“Монголын ураг, удам, уламжлалын холбоо” тус сумын Соёлын төвтэй хамтран төр, төсвийн байгууллагын ажичид, албан хаагч, ерөнхий боловсролын сургуулийн 7-11 дүгээр ангийн сурагчдын дунд 2013 оны 10 дугаар сарын 9-ний өдөр сургалт зохион байгууллаа.

Тус сумын хэмжээний адуунаас бусад малын 7738 төлд бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлж вакцинжуулалт хийлээ.

Тус сумын Засаг даргын Тамгын газраас Малчин, мал бүхий иргэдийн малын эрүүл мэндийн дэвтэрт вакцинжуулалт, тарилгын талаар хяналт шалгалт хийх ажлыг зохион байгууллаа.

#### **16.Түшиг сум:**

2013 оны 10 дугаар сарын 14-ний өдөр тус сумын Засаг даргаар ахлуулсан ажлын хэсэг төр төсвийн байгууллагуудын үйл ажиллагаатай танилцаж, өвөлжилтийн бэлтгэл ажилд хяналт шалгалт хийн, ажилчид албан хаагчидтай уулзалт зохион байгуулж, тулгамдаж буй асуудал, тэдгээрийг шийдвэрлэх арга замын талаар ярилцлаа.

Түшиг сум үүсгэн байгуулагдсаны түүхт 90 жилийн ойн баяр 2014 онд тохиохтой холбогдуулан “Зэлтэр харуулын нутаг” дууны клипний зураг авалтыг тус сумын Өгөөмөр, Хавтгай овоо, Түшиг өндөр, Гурамсан зэрэг байгалийн үзэсгэлэнт газруудад авах ажлыг зохион байгуулж, ахмад, дунд, залуу үеийнхний төлөөллийг хамрууллаа.

2013 оны 7 дугаар сарын 4-ний өдөр болсон байгалийн гамшигт үзэгдэлд Монгол Улсын Засгийн газраас 30 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж, нийт 212 өрхөд тус бүр 141500 төгрөгийг олгож, гамшигт өртөн засвар үйлчилгээ хийгдсэн төсвийн байгууллагуудын байрыг улсын комисс байнгын ашиглалтанд хүлээн авлаа.

Зэлтэр голын үерийн сэтэрсэн хэсэгт далан барих, гүүрний сэтэрсэн хэсэгт 150 метр замыг засч сайжруулах ажлыг “Рэдхил Монголия” ХХК өөрийн хүчээр зохион байгууллаа.

#### **17. Хушаат сум:**

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж буй Орхон гол дээгүүр тавигдаж буй 240м урт төмөр бетонон гүүрний ажил 98 хувьтай, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр баригдаж буй эрүүл мэндийн төвийн стандартын моорог, эргэлтийн эмийн сан, грашийн барилга, сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар баригдаж буй халуун ус, сауны барилгын ажлууд дуусч ашиглалтанд хүлээн авлаа.

“Төрийн захиргааны байгууллагын онцлог, чиг үүрэг”, “Төрийн албан хаагчийн ёс зүй, харилцаа”, “Төрийн захиргааны байгууллага ТББ-тай хамтран ажиллах нь” сэдэвт уулзалт хэлэлцүүлгийг сумын Засаг дарга Тамгын газар, Ахмадын хороотой хамтран зохион байгуулж хэлэлцүүлгээс төрийн албан хаагчдад зориулан зөвлөмж гаргалаа.

Тус сумын Эрүүл мэндийн төв, цэцэрлэг хамтран хүүхдүүдийг эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд бүрэн хамруулан, хүүхдүүдийн дунд “Цэвэр гар” “Хэний гар хамгийн гоё вэ” зэрэг сарын аян зохион байгуулж байна.

“Ажилтай орлоготой Монгол хүн” хөтөлбөрийн хүрээнд аймгийн Хөдөлмөрийн хэлтсээс хувиараа хөдөлмөр эрхлэгч 1 иргэнд сүү, цагаан идээ боловсруулах чиглэлээр 4 сая төгрөгийн тусламж үзүүлэн 2 шинэ ажлын байр бий болголоо.

Аймгийн хэмжээнд үхэр сүргийг сүрьеэ, лейкоз өвчнөөс эрүүлжсэнийг баталгаажуулах тандалт шинжилгээг тус сумын Засаг даргын тамгын газар, аймгийн Мал эмнэлэгийн албатай хамтран хийж 134 үхрийг хамруулан шинжилгээний дээжийг аймгийн Мал эмнэлгийн лабораторит хүргүүллээ.

#### **Найм.Бусад ажлын талаар:**

##### **Стандартчилал хэмжил зүйн хэлтэс:**

Аймгийн Стандартчилал, хэмжилзүйн хэлтсээс Дэлхийн хэмжил зүйн өдрийг тохиолдуулан “METROLOGY 20” шилжин явах цомын төлөөх тэмцээнийг хөрш байгууллагуудын дунд 3 дахь жилдээ зохион байгууллаа. Тэмцээнд аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс, Хүнс, хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрийн газар, Татварын хэлтэс, Стандартчилал, хэмжилзүйн хэлтсийн баг тамирчид оролцлоо.

Сүхбаатар сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй 8 хүнсний дэлгүүр, мини маркетуудын савлан борлуулж буй бүтээгдэхүүний жинд хяналт хийж, холбогдох зөвлөгөө мэдээлэл өглөө.

Сүхбаатар, Сайхан, Орхонтуул, Шаамар сумын 7 аж ахуйн нэгжийн 5 нэрийн 10 хүнсний бүтээгдэхүүнийг баталгаажуулалтанд хамрууллаа.

Дотоодын бүтээгдэхүүний хаяг шошгоны мэдээллийг стандартын шаардлага хангах түвшинд хүргэхэд онцгой анхаарч Сүхбаатар сумын нийт үйлдвэрлэгчдийн дунд “Та стандартын шаардлага хангасан хаяг шошготой бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг үү?” уралдааныг зарлаж, ирүүлсэн хаяг шошгонд “Савласан бүтээгдэхүүний шошгололтонд тавих шаардлага MNS (CAC) 1:2007” стандартын шаардлагын дагуу үнэлгээ хийж, тусгай болзол гарган ажиллаж байна.

Сүхбаатар сумын худалдаа үйлчилгээний 8 аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд арга зүйн зөвлөгөө өгч, 6 нэрийн 9 стандартаар хангах үйлчилгээ үзүүллээ.

Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 7 сургуулийн ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдад “Стандарт гэж юу?” сэдвийн дор стандартын



анхан шатны суурь ойлголт мэдээлэл өгч, Дүрс тэмдгийн стандартын талаар сургалт хийн, “Стандарттай монгол” сэдэвт зохион бичлэгийн уралдаан зарлалаа.

Сайхан, Орхон, Баруунбүрэн сум Дулаанхан тосгонд ажиллаж авто болон худалдааны 25 жинд ээлжит баталгаажуулалт хийлээ.

Сүхбаатар сумын айл өрх, аж ахуй нэгж, албан байгууллагын төлбөр тооцоонд ашиглагдаж буй цахилгааны тоолуурт ээлжит баталгаажуулалт хийлээ.

Сайхан, Орхон, Баруунбүрэн сум, Дулаанхаан тосгоны 11 ШТС-ын 39 шатахуун түгээгүүрт хэмжилт баталгаажуулалтыг хийлээ. Мөн мал эмнэлэг, Мэргэжлийн хяналтын газар, Цемент шохой ХК-ий сорилтын 18 лабораторийн электрон жин, 8 хэмжээст саванд шалгалт тохируулга хийлээ.

#### **Мэргэжлийн хяналтын газар:**

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын баталсан нэгдсэн удирдамжийн хүрээнд тус аймгийн нутаг дэвсгэрт согтууруулах ундааны үйлдвэрлэл, худалдаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүдэд хяналт шалгалтын ажлыг хийж байна. Тайлант сард Сайхан, Орхон, Орхонтуул, Баруунбүрэн, Сант, Сайхан сумдыг хяналт шалгалтанд хамрууллаа.

Нэгдсэн дүнгээр аймгийн Мэргэжлийн хяналтын газраас эхний 10 сарын байдлаар нийт 1485 объектийг хяналт шалгалтанд хамруулж, 2214 зөрчил илрүүлэн, 84200.0 мянган төгрөгийн торгууль шийтгэвэр ногдуулж шийдвэрлээд байна.

Мэргэжлийн хяналтын газрын дэргэдэх итгэмжлэгдсэн лаборатори нь 10 дугаар сард нийт 42 аж ахуйн нэгж, иргэний 12 нэр төрлийн 142 дээжинд 288 үзүүлэлтээр хими, нян судлал, ургамал хорио цээрийн шинжилгээг хийхэд 5 нэрийн 6 дээж 6 үзүүлэлтээр эерэг гарлаа.

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР